

БАТЛАВ:  
"ЭРДЭНЭС КРИТИКАЛ МИНЕРАЛС"  
ТӨҮГ-ЫН ХАРЬЯА БОР-ӨНДӨР  
УБУЙН ЗАХИВАЛ

Б.МАГСАРЖАВ

БАТЛАВ:  
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.СОДМАГНАЙ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ  
ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 05 дүгээр сарын 27-ны өдөр № Бор-Өндөр УБУ

BU-2025-02-07

Нэг. Нийтлэг үндэслэл

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Сумын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө /2025-2028 он/, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /2025он/, сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сумын эдийн засаг, нийгмийг 2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэргийг үндэслэн нэг талаас "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын харьяа "Бор-Өндөр" Уулын баяжуулах үйлдвэрийг төлөөлж Байгаль орчин нөхөн сэргээлт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Мөнххүлэг /цаашид УБУ гэх/, нөгөө талаас Дорноговь аймгийн Иххэт сумыг төлөөлж, ЗДТГ-ын Байгаль орчны бодлогын мэргэжилтэн М.Ганбат /цаашид ЗДТГ гэх/, нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээгээр талууд төрийн үйлчилгээг жигд тасралтгүй, хүртээмжтэй хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.
- 1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөлтэй талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Хоёр. Засаг даргын Тамгын газрын эрх, үүрэг

2.1. Орон нутагт ашигт малтмал олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулахад сумын зүгээс

хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, бүх чиглэлээр хяналт тавьж ажиллана.

2.2. Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.3. Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ. Үйлдвэрийн орчны аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхийг шаардах.

2.4. Сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ. Хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх.

2.5. Ашигт малтмалын салбарын "Шилдэг хөрөнгө оруулагч", "Шилдэг уул уурхай"-г жил бүр шалгаруулна.

2.6 Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.

2.7 "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ нь уул уурхайн төслийг хэрэгжүүлэн ажилладаг учир Монгол улсын газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд сумын ИТХ-аар холбогдох шийдвэрийг тухай бүр гаргуулах.

#### Гурав. УБҮ-ийн хүлээх эрх, үүрэг

3.1 Үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр	2,0 сая.төг
3.2 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:	
- Ногоон байгууламжид ажиллах 2 иргэнийг цалинжуулах	7,92 сая.төг,
3.3 Мод суулгацаар хангах чиглэлээр	10,0 сая.төг
3.4 Соёлын өвийг хамгаалах чиглэлээр	1,0 сая.төг,
3.5 Ногоон байгууламжийн усалгааны систем, булаг шандын эхийг хамгаалах, хөв цөөрөм байгуулах гэх мэт бүтээн байгуулалтын чиглэлээр	30,0 сая.төг
3.6 Хог хаягдал түрэх, хогийн цэгийн ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр	17,5 сая.төг
<b>Нийт</b>	<b>68,42 сая.төг</b>

#### Дөрөв. Хамтран хүлээх үүрэг

4.1. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гарган ажиллана.

4.2. Талууд бичгийн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

4.3. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарах, эсхүл цуцлах тохиолдолд талууд бие биедээ 30 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

#### Тав. Гэрээ дүгнэх

5.1. Энэхүү гэрээний биелэлтийг жил бүрийн эцэст хоёр тал хамтран тооцож дүгнэнэ.

5.2. Гэрээний биелэлтийг "хангалттай", "хангалтгүй" гэсэн үзүүлэлтээр тооцож дүгнэнэ.

5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ "хангалтгүй" биелүүлсэн тохиолдолд дараагийн жилийн үйл ажиллагааг эхлүүлэхгүй бөгөөд гэрээг цуцлах үндэслэл болно.

### Зургаа. Гэрээний хариуцлага

6.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

6.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана.

6.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь хуулийн этгээдийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

### Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

7.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### Найм. Бусад

8.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хойш НЭГ жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

8.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.4 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"БОР-ӨНДӨР" УБУ-ИЙН БАЙГАЛЬ  
ОРЧИН НӨХӨН СЭРГЭЭЛТ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Б.Мөнххулэг-2* Б.МӨНХХҮЛЭГ-2

Утас: 85000111

ТАНИЛЦСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ЗХ-ИЙН ДАРГА

ТЭЗСХ-ИЙН ДАРГА

ЕРӨНХИЙ НЯ-БО

ХУУЛЬЧ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ИХХЭТ СУМЫН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

*М.Ганбат* М.ГАНБАТ

Утас: 9554556

П.МАШБАТ

Ж.ЦОГБААТАР

Б.ИДЭРБАЯР

Д.ОНОН

Ж.ЖАВХЛАН-ЭРДЭНЭ